МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 15 өдөр Дугаар А/132 Алтай хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 82 дугаар тогтоолын дагуу 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулах нээлттэй дуудлагын худалдааг эрхлэн явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Өмчийн төлөөлөгч:П.Бат-Очир -(Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Хөтлөгч: Р.Пүрэвдорж -(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч:Б.Балдорж -(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Нээлттэй дуудлагын худалдааг хууль, журмын дагуу ил тод зохион байгуулж, дүнг холбогдох байгууллагад танилцуулж ажиллахыг комисс (П.Бат-Очир)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ Г.ЧИНБАТ

C:/My documents/-3A-4 doc

0203000460